

ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД

2017 ОН

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал		
	<p>Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг ажилтнуудаас авч, түүний мөрөөр авсан арга хэмжээний тоо;</p>	<p>2016 онд Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи “Эмч ажилчдын сэтгэл ханамж”-ийн судалгааг 6 бүлэг, 54 асуулт бүхий асуумжийн хуудсаар 2 удаагийн давтамжаар, 23 тасагт ажиллаж буй эмч ажилчдын төлөөлөл 200 хүнийг хамруулж судалгаа хийсэн. Судалгааны дүнгээс харахад Сайн -46,9%, дунд-45,3%, муу-7,8% байгаа нь урьд онтой харьцуулахад сайн үнэлгээ нь 6,4%-иар өссөн, муу үнэлгээ нь 1,8%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь эмч ажилчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан, нийгмийн асуудал боломжийн хэмжээнд байгаа гэж үзсэн. Ажилчдаас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар ирсэн санал, хүсэлт, судалгааны дүнд дүгнэлт хийж дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.</p> <p>Үүнд</p> <ul style="list-style-type: none"> • Оройн ээлжийн ажилчдын хоолонд зориулж 5,4 сая төгрөг зарцуулсан. • Ажилчдын цайны газарт засвар хийж гэрээгээр ажиллуулсан. • Ажлын дүрэмт хувцас, хэрэглэлд 26,1 сая төгрөг зарцуулсан. • Эмч ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулан эрүүлжүүлэх ажлыг дотрын их эмч Б.Уранчимэгт хариуцуулан тодорхой хувиар цалинжуулан ажиллуулсан. • Эмч ажилчдыг томуу, гепатит В, улаан бурханы вакцинд хамруулсан • Эмч мэргэжилтнүүдийн мэдээ мэдээлэл авах,сурах орчинг бүрдүүлэн 125 компьютер суурьлуулсан. • Эмч ажилчдын ширээ, сандал тавилганд зориулж 1,7 сая төгрөг • Чанарын алба нь үйлчлүүлэгчээс эмч ажилчдад илгээсэн талархалыг “Үгээр барих бэлэг” мэдээллийн самбарт байршуулах, хамгийн их талархал хүлээсэн эмч ажилтанд “Талархалын эзэн” энгэрийн тэмдэг, хамт олонд дарцаг зэргийг олгож, “Урамын хөтөч”-ийг ажиллуулж байна. Мөн тасаг нэгжүүд Талархалын самбарыг ажиллуулж эмч ажилчдыг урамаар дэмжин ажиллаж байна. <p>Дээрх зохион байгуулсан ажлын үр дүнд эмч, ажилчдын сэтгэл ханамж дээшилснээр ажлын бүтээмж нэмэгдэн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт ахиц гарч байна.</p>
	<p>Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулах журмын дагуу шалгаруулсан ажилтны тоо;</p>	<p>БОЭТ-ийн захирлын 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 08 дугаар тушаалаар баталсан “Сул чөлөөтэй ажлын байранд эмч, ажилтан сонгон шалгаруулах, дадлагажуулан сургах, туршилтаар ажиллуулах, үндсэн ажилтнаар томилох” журмын дагуу IT инженерийн ажлын байранд сонгон шалгаруулалт зарлан шалгалтанд нийт 6 хүний материал ирж Шалгалтын комиссоор Хүний нөөцийн менежер Ц.Цагаан, сургалтын албаны дарга Б.Алтанчимэг, сүлжээний инженер Н.Буянзаяа нар томилогдон гардан үйлдэл, онол, ярилцлага гэсэн дарааллаар шалгаруулж Т.Буяннэмэх 80 оноогоор тэргүүлэн хөдөлмөрийн түр гэрээ байгуулан ажиллуулж байна.</p> <p>Баруун бүсэд Говь-Алтай аймагт АШУҮИС-ын салбар сургууль байдагтай холбоотой манай төвд шинээр ажилд орохоор өргөдөл гарган хандсан эмч, сувилагч тусгай мэргэжилтэн жилд дунджаар нийт 110 гаруй байдаг.</p> <p>2016 онд шинээр өргөдөл өгсөн болон өмнөх онд бүртгэлтэй байсан нийт 107 сувилагч тусгай мэргэжилтнээс “Шинэ сувилагч”</p>

		<p>хөтөлбөрийг боловсруулан онол, гардан үйлдэл, ур чадвар гэсэн үе шатаар шалгаруулалт хийж хүний нөөцийн бүртгэлд эрэмбэлэн авсан. Дээрх шалгалтанд хамрагдсан сувилагч тусгай мэргэжилтнээс 57 сувилагч, тусгай мэргэжилтэн уг шалгуурт тэнцэж хүний нөөцөнд бүртгэж авлаа. Цаашид БОЭТ-д сул болон чөлөөтэй ажлын байр зарлагдсан тохиолдолд хүний нөөцөнд бүртгэгдсэн 57 сувилагч мэргэжилтнээс сонгон шалгаруулалтанд хамрагдах, мөн түр ажлын байранд ажиллах боломжтой юм.</p>
	<p>Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх механизмыг бий болгож, үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд оруулсан өөрчлөлт, хэрэгжилтийн хувь;</p>	<p>БОЭТ-ийн захирлын 2014 оны 351 дугаар тушаалаар БОЭТ-ийн хөдөлмөрийн дотоод журмыг 8 бүлэг 60 зүйлтэйгээр шинэчлэн баталсан. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх механизмыг бий болгож, үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор БОЭТ-ийн ажилчдын үр дүнгийн урамшууллыг дүгнэх журмыг шинэчлэн гаргаж тасаг нэгжийн эрхлэгч, ахлах сувилагч нарт дүгнэх эрхийг олгон, тухай ажилтан зөвшөөрч гарын үсэг зурсан нэгтгэлийг хэлэлцэн шийдвэрлэх комиссыг захирлын тушаалаар батлан хэрэгжүүлэн ажиллаж хэвшсэн.</p> <p>Монгол улсын ЗГ-ын 150 дугаар тогтоолын дагуу эмч ажилчдад улирал бүр урамшуулал олгохдоо тасгийн эрхлэгч, ахлах сувилагчийн гаргасан үнэлгээг харгалзан чанар, сувилахуй, хүний нөөц, эмчилгээ эрхлэсэн орлогч дарга, халдвар судлаач нарын саналыг тусган удирдлагын багаар хэлэлцэн урамшуулалыг олгож байгаа нь үнэн зөв, бодитой үнэлэх боломжийг олгосон үр дүнтэй ажил болсон.</p> <p>2016 оны 07 дугаар сард Чанарын албанаас чанарын урамшуулалын механизмыг хэрэгжүүлж эмч мэргэжилтэн, ажилчдыг дэмжин урамшуулах тухай журам боловсруулан тасаг нэгжүүдийн “Талархлын эзэд” шилжин явах дарцаг, “Талархалын эзэн” тэмдгээр эмч сувилагч тусгай мэргэжилтэн, ажилчин шалгаруулж урамшуулан ажиллах нь үйлчлүүлэгч хамт олны талархалыг хамгийн ихээр хүлээж амжилттай ажилласан эмч ажилчид, тасаг нэгжийг дэмжин урамшуулах үйл ажиллагаа болж байна. Шалгарсан 1 эмч, 1 сувилагч, 1 ажилтаныг сарын цалингийн 10 хувиар урамшуулах ба тэмдэг, дарцагийг аялуулсан нь ажилчдын идэвхийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил болсон.</p> <p>БОЭТ-ийн Сувилахуйн албанаас сувилагч, тусгай мэргэжилтэн нартаа зориулж “Ажлын дэвтэр”-ийг тухайн ажлын байрны онцлог бүрээр, өдөр тутам хөтлөгдөж хийсэн ажлаараа өрсөлдөх, сувилахуйн тусламж үйлчилгээний түгээмэл гардан үйлдлийн стандартаар үнэлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх, санал санаачилгатай ажилласан зэрэг байдлуудаар сувилагчдын ур чадварыг үнэлж урамшуулалд хамрагдах үндэслэл болгож ажиллаж байгаа нь ажилчдын зүгээс талархал хүлээсэн үр дүнтэй шударга шалгуур болсныг үнэлсэн.</p> <p>2016 онд МУ-ын ЗГ-ын 150 дугаар тогтоолоор 200 эмч ажилчдад хэвийн бус нөхцлийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар тооцон 114.961.776, хортой нөхцөлд ажиллаж байгаа 100 эмч ажилчдад хор саармагжуулах сүүг нэг хүнд 300 гр тооцон нийт 8500000 төгрөгийг, онцгой ур чадвар гарган хүний амь нас аварсан 48 эмч мэргэжилтэнд захирлын тушаалаар 19098435 төгрөг, ачаалалтай ажилласан, байгууллага олон нийтийн ажилд идэвхитэй оролцсон 194 эмч ажилчдад 40895010 төгрөгийн урамшуулалыг, нийт эмч ажилчдын улирлын урамшуулалд 238310454 төгрөг, зэргийн нэмэгдэлд 108 эмч мэргэжилтэнд 60369154 төгрөг, ажилчдын хоолны нэмэгдэлд 75066133 төгрөг, илүү цагийн хөлсөнд 151016253 төгрөгийг, гэрт болон галалгаатай байшинд амьдардаг эрэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд нийт 49 ажилтанд түлшний хөнгөлөлт тус бүр 1тн нүүрний үнэ 90000 төгрөгөөр тооцон</p>

		4410000 төгрөг, алс болон хот дотор дуудагдсан эмч мэргэжилтэн, жижүүр эмчийн нэмэгдэлд 227491161 төгрөгийг тус тус цаг хугацаанд нь олгон урамшуулж ажилласан.
	Ажилтнуудыг сургах, орчин үеийн мэдээллээр хангах дэд бүтцийг бүрдүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь;	<p>БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгосон хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй 18,9 сая америк долларын өртөг бүхий “Цахим эрүүл мэнд төсөл”-ийн хүрээнд тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, программ хангамж болон хүний нөөцийн чадавхийг сайжруулах үйл ажиллагаанд зарцуулсан. Нийтдээ 125 компьютер болон бусад 23 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж Цахим сургалтын өрөө тохижуулан ажиллаж байна. Мөн байгууллага бүрэн цахижсанаар нийт эмч нарт Health Info3 программын ашиглалт, дотоод сүлжээний талаар танхимын болон ажлын байран дахь хэлбэрээр өдөр тутмын сургалтыг хийж, эмч нарын программ ашиглалтыг сайжруулснаар эмч ажилчдын компьютерийн хэрэглээний программууд дээр ажиллах мэдлэг, ур чадвар сайжирч улмаар орчин үеийн мэдээ мэдээлэл, мэргэжлийн холбогдолтой шинэ дэвшилтэт эмчилгээ оношилгооны арга техниктэй танилцах, зайн сургалтанд хамрагдах боломж бололцоо бүрдсэн.</p> <p>Зайн сургалтаар 11 сувилагч тусгай мэргэжил Дархан уул аймгийн АШУҮИС-ийн салбар сургуулийн баклавын сургалтыг амжилттай дүүргэн боловсролын түвшингээ ахиулсан, 2 их эмч, 1 IT инженер АШУҮИС-ийн САЙБЕР их сургуулийн магистрийн хөтөлбөрт хамрагдан суралцаж байна.</p> <p>Ховд аймгийн БОЭТ-ийн цахим сургалтын танхимд эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн бичгийн шалгалтыг эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран цахим хэлбэрээр 1 цаг 40 минутын хугацаатай авлаа. Нийт 15 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Ингэснээр хөндлөнгийн нөлөөгүй, ил тод, шуурхай, нээлттэй Цахим хэлбэрээр өгсөн шалгалтын дүнг вэб сайтад шууд байрлуулах, дүнг газар дээр нь тоцоолж мэдээлэх зэргээр хурдан, шуурхай байдлыг хангаж мөн Хөдөө орон нутагт байгаа эмч эмнэлгийн мэргэжилтний цаг хугацаа, хувь хүний төсөв зардалыг хэмнэж тухайн орон нутагт ажиллах хугацаандаа эмчлэх сувилах эрхийн шалгалтыг өгөх боломжтой болсон.</p> <p>Ажилтнуудыг сургах, орчин үеийн мэдээллээр хангах дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор Мобиком дахь салбартай хамтран ажиллах гэрээ байгуулан интернетийн хурдын нэмэгдүүлэн ажиллаж байна. цаашид эмнэлгийн орчныг WI-FI болгох зорилт тавин ажиллаж байна.</p>
	Нээлттэй зарласан сургалт, сонгон шалгаруулалтын тухай мэдээллийн тоо;	<p>БОЭТ-ийн захирлын 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 08 дугаар тушаалаар баталсан “Сул чөлөөтэй ажлын байранд эмч, ажилтан сонгон шалгаруулах, дадлагажуулан сургах, туршилтаар ажиллуулах, үндсэн ажилтнаар томилох” журмын дагуу IT инженерийн ажлын байранд, эмчилгээний хоолны тасгийн “Хоолны технологич инженер”-ийн ажлын байранд сонгон шалгаруулалтын зарыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлсэн.</p> <p>Эрүүл мэндийн хөгжлийн төвийн сул ажлын байрны зарын хэсэгт http://chd.mohs.mn/content.php?id=6&cid=824/ БОЭТ-д нэн шаардлагатай байгаа тархи нугасны мэс засалч эмч, вирус судлаач эмч, эмчилгээний хоол зүйч эмч, гадаадын оронд магистраас дээш зэрэг хамгаалсан эмчийг ирж ажиллахыг урьж орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор аймгийн ЗДТГ-аас орон байраар ханган 5-аас дээш жил ажиллавал тухай байрыг өөрт нь үнэ</p>

		<p>төлбөргүй шилжүүлэх урилга байршуулсан боловч одоогоор хүсэлт ирээгүй байна.</p> <p>Эмч эмнэлгийн мэргэжилтний мэргэжил олгох сургалтыг нээлттэй зарлаж нийт 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй гэрээ хийж байгууллагын зардлаар суралцуулж байна.</p>
	<p>Эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудлыг шийдэхэд үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа байдал, хамтын гэрээний биелэлтийн хувь.</p>	<p>БОЭТ-ийн захиргаа, Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороо нь 2016-2018 онд хэрэгжих “Хамтын гэрээ”-г шинээр боловсруулан 12 бүлэг 79 зүйл бүхий гэрээг 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдөр батлан гаргасан гэрээг 2016 онд мөрдөж ҮЭХ-той хамтран ажиллаа.</p> <p>2016-2018 онд хэрэгжүүлэх хамтын гэрээнд хамт олны санаачилгаас гарсан дараах заалтуудыг 2 тал харилцан тохиролцож шинээр нэмж оруулсан нь онцлог зүйл байсан. Үүнд</p> <p>2.6 Ажилчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарал тавьж, байгууллагын шаардлагаар гадаад оронд суралцахаар явж буй тохиолдолд цалинг олгож, ажлын байрыг хадгална. Гадаад оронд суралцах хугацаа нь 6 сар хүртэл бол цалинг 100% олгож, суралцах хугацаа нь 6 сараас дээш бол цалинг 60% олгож, ажлын байрыг хадгална. Суралцах гэрээг 2 жилээр хийнэ.</p> <p>1.6.1 Мэргэжлийн зэрэг олгох шалгалт өгч байгаа тохиолдолд үндсэн цалинг 60%-иар олгоно. Сургалтын төлбөрөө өөрсдөө даана. (Зэрэг хамгаалсан тохиолдолд нэг талын унааны зардалыг автобусаар олгох)</p> <p>1.6.2 Эмнэлгийн мэргэжлийн болон мэргэжлийн бус мэргэжил дээшлүүлэх сургалтанд сурч байгаа тохиолдолд үндсэн цалинг 100% олгоно. Сургалтын төлбөрийг өөрөө хариуцна. Суралцагчийн үндсэн ажлыг тасаг нэгж хариуцах бөгөөд ажлын ачаалаас хамаарч ЭЭО даргын саналыг харгалзан захирлын тушаалаар цалингийн хувь олгоно.</p> <p>1.6.3 Зэргийн шалгалтанд явсан хугацаанд цалинг 60%-иар олгож, хамт олонд нь 40%-ийг хавсруулан олгох</p> <p>1.6.4 Докторт сурч байгаа үед 6 сарын хугацаанд 100% цалинг олгож, гэрээг 3 жилийн хугацаатай, Магистрын зэрэг хамгаалахаар сурч байгаа үед цалингийн 60%-ийг 4 сарын хугацаанд олгож, суралцах гэрээг 2 жилээр хийнэ.</p> <p>1.6.5 Резидент сургалтанд суралцагч өөрөө төлбөрөө төлж байгаа тохиолдолд 2 жилийн хугацаатай гэрээ хийж үндсэн цалинг 100 хувь олгоно. Суралцагч нь төрийн сангаар сурч байгаа тохиолдолд 2 жилийн хугацаатай гэрээ хийж эхний 3 сар үндсэн цалинг 100 хувь үлдсэн саруудад цалинг 60 хувиар олгоно.</p> <p>3.6.3 Эхнэр, нөхөр, хүүхэд нь хүнд өвчнөөр өвдөж өөрөө асрамжилж байгаа тохиолдолд ажлын 22 хоног хүртэл хоногийн цалинтай чөлөө олгоно /эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр/</p> <p>3.7 Эмчлэх, эм барих, зөвшөөрлийн хугацаа нь дуусч өөрсдийн буруугаас сунгагдаагүй тохиолдолд 2-3 сарын цалингүй чөлөөг уг ажилтанд олгоно. Дээрх хугацаанд ажлын байрыг хадгална</p> <p>4.1. Ажилтанд эрдмийн цол, мэргэжилийн зэрэг, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэлийг олгоно. Үүнд:</p> <p>4.1.1. Эрдмийн болон боловсролын зэргийн нэмэгдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Доктор (Ph.D) 20% • Магистр (хамгаалсан сэдэвтэй) 15% • Клиникийн профессор (захирлын тушаалаар) 10% <p>4.1.2. Мэргэжилийн зэргийн нэмэгдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Зөвлөх зэргийн эмч, сувилагч 20% • Тэргүүлэх зэргийн эмч, сувилагч 15% • Ахлах зэргийн эмч, сувилагч 10%

		<p>4.1.3. Зэрэг давхардсан тохиолдолд аль нэмэгдэлээ авахаа ажилтан өөрөө сонгоно</p> <p>4.2. Ур чадварын нэмэгдэлийг сар бүр ажлыг шударга зөв дүгнэж, улирал тутам Засгийн Газарын 150-р тогтоолын дагуу олгож байна</p> <p>4.3. Тасгийн эд хариуцагч нарт 20000 төгрөг, эд хөрөнгө хариуцагчын нэмэгдэл олгох сар бүр</p> <p>4.4. Урлаг, спортын Аймаг, Бүс, Улс, Тив, Дэлхийн тэмцээнд амжилт гаргасан ажилтанд цалингийн хувь олгоно</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн чанартай тэмцээнд 10%-15% • Бүс болон Улсын чанартай тэмцээнд 15%-20% • Тив, Дэлхийн чанартай тэмцээнд /Захирлын тушаалаар/ <p>5.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйл (үер, ус,гал,түймэр)-д орсон, орон байр нь нэрвэгдсэн тохиолдолд холбогдох байгууллагын гаргасан акт, баримтыг үндэслэн ажилчдын хандиваар 1 000 000 төгрөгний тэтгэмж олгоно</p> <p>5.2. Нэг өдрийн оройн ээлжинд ажиллагсдад оройн хоолтой болгоно</p> <p>8.1.1. Онцгой байдлын үед онцгой үүрэг гүйцэтгэсэн, шинэ санаачлага гарган ажиллаж буй ажилтанд хамт олны өмнө сайшааж, цалингийн 20-30%-иар, 1-3 сар хүртэлх хугацаагаар нэмж урамшуулах</p> <p>8.1.2. Байгууллагадаа өөрийн идэвх санаачлагаар дотоод, гадаадын хөрөнгө оруулалт хийсэн, шинэ техник технологи нэвтрүүлсэн эмнэлгийн мэргэжилтэнд 500,000₮-1,000,000₮ хүртэл төгрөгний урамшуулалыг захирлын зөвлөлөөр шийдвэрлэж олгоно</p> <p>2016 онд байгууллагын ҮЭХ-ны гишүүдийн татвараас 21,6 сая төгрөг төвлөрсөнөөс зарцуулалтыг харуулбал</p> <ol style="list-style-type: none"> 1. ҮЭХ-ны татварт 4,3 сая төгрөг 2. Цалин 4,4 сая төгрөг 3. Олон нийтийн ажилд 4,9 төгрөг 4. Буцалтгүй тусламж -7,9 сая төгрөг байна. <p>Монголын Эрүүл мэндийн үйлдвэрчний эвлэлийн холбооноос сургалт авч тасаг бүрээс 5 хүн нийт 120 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж Эмнэлгийн үйлдвэрчний хорооний эрх үүрэг, гишүүдийн оролцоо зэрэг хууль эрх зүйн мэдлэг олголоо. Хамтын гэрээний биелэлт 96 хувьтай байна.</p>
--	--	--